

**Захиргааны хураамж нь БНЧУ-ын
Дотоод хэргийн яамнаас явуулж
буй үйлчилгээний хураамж юм.**



ЗАХИРГААНЫ ХУРААМЖ

Үйлчилгээний хураамжид дараах зүйлс багатна жишээлбэл:

- БНЧУ-ын нутаг дэвсгэрт виз олгох өргөдлийг хүлээн авах (мөн сунгалтууд),
- олон улсын гэрээний дагуу олгосон аяллын үнэмлэх, аяллын баримт бичгийн өгөгдлийг өөрчлөх хүсэлтийг хүлээн авах,
- урт хугацааны оршин суух зөвшөөрөл эсвэл байнгын оршин суух зөвшөөрөл олгох өргөдлийг хүлээн авах (мөн сунгалтууд),
- ЕХ-ны иргэдийн бүртгэлийн гэрчилгээ олгох өргөдлийг хүлээн авах,
- ЕХ-ны иргэний гэр бүлийн гишүүний түр оршин суух зөвшөөрөл олгох өргөдлийг хүлээн авах,
- оршин суугаа газрын гэрчилгээ олгох,
- үнэмлэх гэмтэх, үрэгдэх эсвэл алдах,
- танд хадгалагдаж буй албан хэргийн хуулбар, баримтын хуулбар, зургийн хуулбар болон бусад хуулбарыг олгох.

Та бүх захиргааны хураамжийн жагсаалтыг эндээс олж болно:

<https://frs.gov.cz/spravni-rizeni/poplatky-obcane-tretich-zemi/>

<https://frs.gov.cz/spravni-rizeni/poplatky-obcane-eu-a-jejich-rodinni-prislusnici/>

Төлбөрийг үнэт марк хэлбэрээр төлдөг (kolkových známek).

- [Чех шуудангийн салбараас](#) худалдаж авна.
- Нэгэн зэрэг олон үйлдэл хийсэн тохиолдолд (нэг захиалгын огнооны дотор) үйлдэл бүрд тамга худалдан авах шаардлагатай.
- Маркийг өргөдөлтэй хамт хавсаргасан.
- Маркийг үргэлж тодорхой заасан хэмжээгээр худалдаж авах ёстой. Хэрэв та өндөр үнэтэй марк худалдаж авбал зөрүүг буцаан олгохгүй.
- Өргөдлийг шуудангаар явуулахдаа бусад баримт бичигт маркаа явуулна.

*Дотоод хэргийн яамны ажлын байранд бэлнээр болон зээлийн картаар төлөх боломжгүй.
Цорын ганц хамаарах зүйлс бол баримтын хуулбар, зургийн хуулбар эсвэл гадаадын
иргэний баримтын хуулбарыг бэлэн мөнгөөр төлбөр төлнө.*



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Poradna
pro integraci

Projekt "Centrum na podporu
integrace cizinců v Ústeckém kraji" reg.
č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je
financován OP AMIF a MV ČR.